



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар Б/85

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж,
түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тухай 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Бадамцэцэгийн хүсэлтийг үндэслэн түүний хөдөлмөрийн гэрээг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс цуцлан үүрэгт ажлаас нь чөлөөлж, тус сургуулийн сургалтын менежер И.Насантогтохыг сургуулийн захирал томилогдох хүртэл хугацаанд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т даалгасугай.

3. Д.Бадамцэцэгтэй зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусган захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх И.Насантогтохын цалинг ТҮБД-н 7-ын 4 дүгээр шатлал 713968 /долоон зуун арван гурван мянга есөн зуун жаран найман/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Э.Мөнхмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Д.Бадамцэцэгийг ажил хүлээлцсэн өдрөөс эхлэн ажлын байраар хангаж ажиллахыг сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх И.Насантогтоход даалгасугай.

5. Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх И.Насантогтохын ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА